# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 33 (558)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай*
- *Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Үндэсний хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2008 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот | 2008 оны есдүгээр сарын 7 | №33 (558)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 560. | Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай | Дугаар 01 | 957 |
| 561. | Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай | Дугаар 02 | 959 |
| 562. | Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай | Дугаар 03 | 959 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|---|---|---|---|
| 563. | Энхбатын Бадар-Ууганд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай | Дугаар 243 | 959 |
| 564. | Отрядын Гүндэгмаад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай | Дугаар 244 | 959 |
| 565. | Пүрэвдоржийн Сэрдамбад Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай | Дугаар 245 | 960 |
| 566. | Эрдэмтэн, мэргэжилтнүүдийн зөвлөлийн гишүүнээс чөлөөлж, томилох тухай | Дугаар 246 | 960 |
| 567. | Оройн нэгдсэн тооллого хийх тухай | Дугаар 247 | 960 |
| 568. | Элчин сайдыг томилох, чөлөөлөх тухай | Дугаар 263 | 961 |
| 569. | Зарим хүмүүсийг аймаг, сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 269 | 961 |
| 570. | Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 270 | 961 |
| 571. | Шүүгчийн бүрэн эрхийг сэргээх тухай | Дугаар 271 | 962 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 572. | Төлөвлөгөө батлах тухай | Дугаар 265 | 962 |
| 573. | Хөтөлбөр батлах тухай | Дугаар 267 | 966 |
| 574. | Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 270 | 968 |
| 575. | Үйл ажиллагааны чиглэл батлах тухай | Дугаар 284 | 968 |
| 576. | Хөтөлбөр батлах тухай | Дугаар 288 | 976 |
| 577. | Үндэсний хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай | Дугаар 289 | 978 |
| 578. | 2008-2009 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай | Дугаар 290 | 981 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 01 | Улаанбаатар хот

### Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

2008 оны 6 дугаар сарын 29-ний өдөр явуулсан Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүн, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон дор дурдсан нэр бүхий гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй:

1 дүгээр тойрог
- Нямжавын Батбаяр
- Раднаасүмбэрэлийн Гончигдорж
- Самбуугийн Ламбаа

2 дугаар тойрог
- Хавдисламын Баделхан
- Халидолдагийн Жекей
- Алмаликийн Тлейхан

3 дугаар тойрог
- Батжаргалын Батбаяр
- Халтмаагийн Баттулга
- Гомбожавын Занданшатар

4 дүгээр тойрог
- Энэбишийн Мөнх-Очир
- Цэгмидийн Цэнгэл

5 дугаар тойрог
- Цэдэвийн Дашдорж
- Жадамбын Энхбаяр

6 дугаар тойрог
- Жамъянсүрэнгийн Батсуурь
- Яйчилын Батсуурь

8 дугаар тойрог
- Халзхүүгийн Наранхүү
- Раднаабазарын Раш

9 дүгээр тойрог
- Догсомжавын Балдан-Очир
- Дуламсүрэнгийн Оюунхорол
- Шинэнсамбуугийн Сайхансамбуу

10 дугаар тойрог
- Гаваагийн Батхүү
- Дашзэвэгийн Зоригт
- Данзангийн Лундээжанцан
- Зандаахүүгийн Энхболд

11 дүгээр тойрог
- Хоохорын Бадамсүрэн
- Цэвэлмаагийн Баярсайхан

12 дугаар тойрог
- Рэнцэнгийн Буд
- Чүлтэмийн Улаан

13 дугаар тойрог
- Эрдэнийн Бат-Үүл
- Сангажавын Баярцогт
- Очирбатын Чулуунбат

14 дүгээр тойрог
- Сундуйн Батболд
- Долгоржингийн Дондог
- Миеэгомбын Энхболд
- Нямаагийн Энхболд

15 дугаар тойрог
- Цэндийн Нямдорж
- Чимэдийн Хүрэлбаатар
- Баттогтохын Чойжилсүрэн

16 дугаар тойрог
- Ринчиннямын Амаржаргал
- Сандагийн Бямбацогт
- Дамдины Дэмбэрэл

17 дугаар тойрог
- Ламжавын Гүндалай
- Цэрэнпилийн Даваасүрэн
- Цэрэнбатын Сэдванчиг
- Өлзийсайханы Энхтүвшин

18 дугаар тойрог
- Дашжамцын Арвин
- Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
- Наваансамдангийн Ганбямба

19 дүгээр тойрог
- Лүймэдийн Гансүх
- Жамъянхорлоогийн Сүхбаатар
- Дамдингийн Хаянхярваа

20 дугаар тойрог
- Дорждамбын Дамба-Очир
- Дүрэээгийн Одхүү

21 дүгээр тойрог
- Лувсанвандангийн Болд
- Дэлэгийн Загджав

22 дугаар тойрог
- Зоригийн Алтай
- Цогтын Батбаяр
- Даваажавын Ганхуяг
- Чимэдийн Сайханбилэг

23 дугаар тойрог
- Сүхбаатарын Батболд
- Санжаагийн Баяр
- Лувсаннямын Гантөмөр

24 дүгээр тойрог
- Гарьдхүүгийн Баярсайхан
- Дагвадоржийн Очирбат

26 дугаар тойрог
- Норовын Алтанхуяг
- Даваагийн Кёкүшюзан Батбаяр
- Дэндэвийн Тэрбишдагва

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2008 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр** **Дугаар 02** **Улаанбаатар хот**

### Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 26 дугаар тойрогт 2008 оны 6 дугаар сарын 29-ны өдөр явуулсан ээлжит сонгуулийн дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Санжаасүрэнгийн Оюуны бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2008 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр** **Дугаар 03** **Улаанбаатар хот**

### Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.2 дахь заалт, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргаар Улсын Их Хурлын гишүүн Дамдины Дэмбэрэлийг сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ С.ЛАМБАА**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 24-ний өдөр** **Дугаар 243** **Улаанбаатар хот**

### Энхбатын Бадар-Ууганд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Даян дэлхийн спортын их баяр наадамзуны олимпийн XXIX наадмын боксын төрөлд гарамгай амжилт гарган Монгол Улсын түүхэнд олимпийн анхны аварга хэмээх эрхэм дээд алдрыг хүртсэн Монгол Улсын гавъяат тамирчин Энхбатын Бадар-Ууганд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 25-ны өдөр** **Дугаар 244** **Улаанбаатар хот**

### Отрядын Гүндэгмаад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

1996 оны Атлантын олимп, 2000 оны Сиднейн олимп, 2004 оны Афины олимпийн наадмын шагналт байруудад тогтмол шалгарч, Дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээний 6 удаагийн алтан медальт, 2008 оны Бээжингийн олимпийн XXIX наадмын буудлагын спортын төрөлд гарамгай амжилт гарган олимпийн рекорд амжилтыг давтаж, монголын эмэгтэй тамирчдаас анх удаа олимпийн наадмаас мөнгөн медаль хүртсэн Монгол Улсын гавъяат тамирчин Отрядын Гүндэгмаад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 08 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 245 | Улаанбаатар хот

**Пүрэвдоржийн Сэрдамбад Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай**

Бээжин хотноо зохиогдсон зуны олимпийн XXIX наадмын боксын төрөлд гарамгай амжилт гарган олимпийн мөнгөн медаль хүртсэн, оюутны дэлхийн аварга шалгаруулах тэмцээний хүрэл, Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний алтан медальт, боксын олон улсын хэмжээний мастер Пүрэвдоржийн Сэрдамбад Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 08 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 246 | Улаанбаатар хот

**Эрдэмтэн, мэргэжилтнүүдийн зөвлөлийн гишүүнээс чөлөөлж, томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хуулийн 17 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Эрдэмтэн, мэргэжилтнүүдийн Бизнесийг хөгжүүлэх бодлогын салбар зөвлөлийн гишүүнээс Ш.Сайхансамбуур чөлөөлж, "Нарантуул" олон улсын худалдааны төвийн захирал Шинэнсамбуугийн Батсамбууг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 08 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 247 | Улаанбаатар хот

**Оройн нэгдсэн тооллого хийх тухай**

Хүн төрөлхтний эв найрамдлын бэлэг тэмдэг, их спортын баяр-зуны олимпийн XXIX наадамд эх орон, ард түмнээ төлөөлөн оролцсон тамирчин Н.Түвшинбаяр, Э.Бадар-Ууган нар улсынхаа түүхэнд олимпийн аваргын анхны алтан медаль, О.Гундэгмаа, П.Сэрдамба нар мөнгөн медаль хүртэн, эр зориг, ухаан самбаа, ур чадвар, тэсвэр хатуужлаар өрсөлдөгчөөсөө шалгарч гарамгай амжилт үзүүлснийг бахархан тэмдэглэж, цэрэг, цагдаагийн албан хаагчдын үндэсний бахархал, эх оронч үзэл, хүмүүжил, үлгэр дууриаллыг дэмжин дэлгэрүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 13 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасныг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсын хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин Н.Түвшинбаяр, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин Э.Бадар-Ууган, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин О.Гундэгмаа, Монгол Улсын гавьяат тамирчин П.Сэрдамба нарыг алдаршуулан хүндэтгэх оройн нэгдсэн тооллогыг цэрэг, цагдаагийн бүх анги, салбар, хүрээнд Монгол Улсын Цэргийн дотоод албаны дүрмийн тавдугаар бүлгийн 17 дугаар зүйлд заасан ёсоор хийсүгэй.

2. Оройн нэгдсэн тооллогыг 2008 оны 8 дугаар сарын 29-ний 21.00 цагаас зохион байгуулахыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, дэслэгч генерал Ц.Тогоо, Хил хамгаалах Ерөнхий газрын дарга, хошууч генерал А.Баатарцогт, Цагдаагийн Ерөнхий газрын дарга бөгөөд Дотоодын цэргийн даргын үүрэг гүйцэтгэгч, хошууч генерал Ч.Амарболд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын дарга, бригадын генерал Д.Батжаргал нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 08 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 263 | Улаанбаатар хот

### Элчин сайдыг томилох, чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Австрали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Жамбалдоржийг тохоон томилсугай.

2. Галсангийн Батсүхийг Монгол Улсаас Австрали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр | Дугаар 269 | Улаанбаатар хот

### Зарим хүмүүсийг аймаг, сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.4 дэх хэсгийг тус тус баримтлан Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цогийн Очийг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Батжаргалын Батзоригийг Говьсүмбэр аймгийн шүүхийн шүүгчийн, Амаржаргалын Алтанхуяг, Төмөртогоогийн Энхжаргал нарыг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Гармаадоржийн Мөнхбатыг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Дагвадоржийн Мөнхтуяаг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Борисын Отгонтуяаг Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр | Дугаар 270 | Улаанбаатар хот

### Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.1, 58.1.2 дахь хэсгийг тус тус баримтлан Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөрөө хүсэлт гаргасан тул Ноостын Хонинхүүг Говь-Алтай аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Даваацэрэнгийн Сарантуяаг Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, төрийн өөр ажил, албан тушаалд томилогдох болсон тул Батжаргалын Батзоригийг Ховд аймгийн шүүхийн шүүгчийн, Цогийн Очийг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр | Дугаар 271 | Улаанбаатар хот

**Шүүгчийн бүрэн эрхийг сэргээх тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2008 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 234 тоот албан бичиг, саналыг тус тус үндэслэн Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Цэдэвийн Оттонжаргалын шүүгчийн бүрэн эрхийг сэргээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 265 | Улаанбаатар хот

**Төлөвлөгөө батлах тухай**

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн байгууллагад чанарын удирдлагын тогтолцооны олон улсын ISO 9000 стандартыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 1 дүгээр, Төрийн үйлчилгээний болон хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хангах чиглэлээр стандарт бий болгож, мөрдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоолоор баталсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг өөрийн эрхлэх ажлын хүрээ, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Төрийн албаны зөвлөл (Ж.НОРОВСАМБУУ)-д зөвлөсүгэй.

3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаанд, хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД М.ЭНХБОЛД**

**Засгийн газрын 2008 оны 265 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт**

### ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ОЛОН УЛСЫН ISO 9000 СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ, арга хэлбэр | Хэрэгжүүлэх байгууллага | Оролцох байгууллага | Хугацаа (оноор) |
|---|---|---|---|---|
| | 1. Төрийн байгууллагын үйл ажиллагааны менежментийн шинэ тогтолцоог бий болгож эхлэх | | | |
| 1.1 | Төрийн байгууллагын ажилтнуудад зориулж чанарын удирдлагын тухай олон улсын (ISO 9000) бүлэг стандартын эмхтгэл, гарын авлага бэлтгэж хэвлүүлэх:<br>а) эмхтгэн хэвлэлийн эх бэлтгэх;<br>б) хэвлүүлэх;<br>в) төрийн байгууллагуудад хуваарилан хүргүүлэх | СХЗТ | Холбогдох яам, Засгийн газрын агентлаг | 2008 |
| 1.2 | Чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцоо (ISO 9000, ISO14000)-ны стандартыг хянан, шинэчлэх, иж бүрдэл уялдааг нь сайжруулах | СХЗТ | - | 2008-2009 |
| | 2. Сургалт, сурталчилгаа явуулах | | | |
| 2.1 | Төрийн байгууллагын удирдах ажилтнуудад зориулсан анхан шатны сургалт зохион байгуулж, гэрчилгээ олгох:<br>а) яамдын Төрийн нарийн бичгийн дарга нар;<br>б) яам, агентлагийн Төрийн захиргааны Удирдлагын газрын дарга нар;<br>в) аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нар | СХЗТ | СХЗТ<br>ТАЗ | 2008-2009 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.2 | Яам, Засгийн газрын агентлагийн чанарын менежерийн 3 өдрийн сургалт зохион байгуулах | СХЗТ | ТАЗ | 2009 |
| 2.3 | Аймаг, нийслэл, дүүргийн чанарын менежерийн 3 өдрийн сургалт зохион байгуулах | СХЗТ | ТАЗ | 2009 |
| 2.4 | Бусад сургалт:<br>-холбогдох байгууллагад газар дээр нь сургалт явуулах<br>-чанарын удирдлагын тогтолцооны нарийвчилсан сэдэвт сургалт | СХЗТ | ТАЗ | 2009 |
| 2.5 | ISO 9000 стандартыг нэвтрүүлэх байгууллагын ажилтнуудыг гадаадад чанарын удирдлагын чиглэлээр зохиогдох сургалт, семинар, бусад арга хэмжээнд оролцуулах боломжийг судалж, хэрэгжүүлэх | ЗГХЭГ<br>СХЗТ | Холбогдох яам, Засгийн газрын агентлаг | 2009-2010 |
| 2.6 | Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын стандарт (ISO 9000)-ыг нэвтрүүлсэн өөрийн болон гадаад орны төрийн байгууллагад туршлага судлуулах | ЗГХЭГ<br>СХЗТ | ТАЗ, холбогдох яам, Засгийн газрын агентлаг | 2008-2010 |
| 2.7 | Дээр дурдсан сургалт, бусад арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулах:<br>а) жилийн төлөвлөгөө, график боловсруулах, ажлын төлөвлөгөөнд тусгах;<br>б) төлөвлөгөөг холбогдох газруудад хүргүүлэх;<br>в) төлөвлөгөөний дагуу холбогдох байгууллагуудыг оролцуулах;<br>г) сургалт явуулах;<br>д) гэрчилгээ олгох | СХЗТ | ТАЗ | 2008-2010 |
| 2.8 | Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын стандартыг таниулах талаар тогтмол сурталчлах<br>-хэвлэлд нийтлэх<br>-телевиз, радио, бусад мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх | СХЗТ | Холбогдох яам, Засгийн газрын агентлаг, ТАЗ | 2008-2010 |
| 2.9 | Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлсэн байгууллагын туршлагыг сурталчлах | СХЗТ | ТАЗ, холбогдох яам, агентлаг | 2009 |
| | 3. Чанарын удирдлагын тогтолцоог зарим төрийн байгууллагад нэвтрүүлж, хэрэгжүүлэх, баталгаажуулах | | | |
| 3.1 | Дараахь байгууллагад чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж хэрэгжүүлэх:<br>-Зам, тээвэр, аялал жуулчлалын яам;<br>-Иргэний нисэхийн ерөнхий газрын зарим хэлтэс, албад;<br>-Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв;<br>-Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар;<br>-Өвөрхангай, Завхан аймгийн Стандартчилал, хэмжил зүйн төв;<br>-Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар | СХЗТ | - | 2008-2011 |
| 3.2 | Чанарын удирдлагын тогтолцоог баталгаажуулалтад бэлтгэх, гэрчилгээ авах:<br>а) өргөдөл, танилцуулга, бусад материалыг бэлтгэх;<br>б) баталгаажуулалтын байгууллагад албан ёсоор хандах | Холбогдох байгууллагууд | - | 2009-2011 |
| 3.3 | Баталгаажуулалт хийх, гэрчилгээ олгох | СХЗТ | - | Тухай бүр |
| 3.4 | Баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэх | СХЗТ | Холбогдох байгууллага | 2008-2010 |

Засгийн газрын 2008 оны 265 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

## ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОЛОН ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР СТАНДАРТ БИЙ БОЛГОЖ МӨРДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцаж, хэрэгжүүлэх байгууллага | Хугацаа (оноор) |
|---|---|---|---|
| | 1. Төрийн үйлчилгээний төрлүүдээр стандарт бий болгох | | |
| 1.1 | Төрийн үйлчилгээний чанар, шуурхай байдлын багц стандарт боловсруулах:<br>-үл хөдлөх хөрөнгийн бүртгэл;<br>-иргэний бүртгэл мэдээлэл;<br>-нийгмийн даатгал;<br>-гааль;<br>-газрын алба;<br>-татварын үйлчилгээ;<br>-нийгмийн халамж, үйлчилгээ;<br>-хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд үзүүлэх үйлчилгээ | Холбогдох яам, Засгийн газрын агентлаг, ТАЗ | 2008-2010 |
| 1.2 | Зарим төрийн захиргааны төв байгууллагад стандартчилал, техникийн зохицуулалт хариуцсан нэгж бий болгох асуудлыг судлах | Сайд нар | 2008 |
| | 2. Хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хангах зорилгоор бүх салбарт үндэсний стандартыг олон улсын жишигт хүргэх | | |
| 2.1 | Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр | | |
| 2.1.1 | Хүнд металл, пестицид, хоруу чанар, микробиологийн болон цацрагийн хэмжээ, тэдгээрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлтийг тусгасан стандарт шинээр боловсруулах, шинэчлэх | ХХААЯ, УМХГ, СХЗТ, холбогдох бусад байгууллагууд | 2008-2010 |
| 2.2 | Орон сууц, дэд бүтцийн чиглэлээр | | |
| 2.2.1 | Зам, гүүр, барилгын материалын эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлтийг тусгасан стандарт шинээр боловсруулах, шинэчлэх | БХБЯ, ЗТАЖЯ, СХЗТ | 2008-2010 |

| | | | |
|---|---|---|---|
| 2.2.2 | Төмөр замын болон авто тээврийн аюулгүй байдлыг хангах зорилгоор холбогдох бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний стандартыг боловсруулах | ЗТАЖЯ, СХЗТ, холбогдох байгууллагууд | 2008-2010 |
| 2.3 | Байгаль орчны чиглэлээр | | |
| 2.3.1 | Экологийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай агаар, ус, хөрсний эрүүл ахуйн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ болон шинжилгээний аргын стандартыг шинээр боловсруулах, шинэчлэх | БОЯ, СХЗТ, холбогдох байгууллагууд | 2008-2010 |
| 2.3.2 | Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, хаягдлын стандартыг шинээр боловсруулах, шинэчлэх | - | - |
| 2.3.3 | Байгаль орчны салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулах | - | - |
| 2.4 | Эрчим хүчний чиглэлээр | | |
| 2.4.1 | Сэргээгдэх эрчим хүчний барилга байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар, үйлчилгээний стандарт, норматив боловсруулах, батлуулах | ТЭХЯ, СХЗТ, холбогдох байгууллагууд | 2008-2010 |
| 2.5 | Экспортын баримжаатай үйлдвэрлэлийн чиглэлээр | | |
| 2.5.1 | Ноос, ноолуур, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ, шинжилгээний аргын стандартыг шинээр боловсруулах, шинэчлэн тогтоох | ҮХЯ, СХЗТ | 2008-2010 |
| 2.6 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны чиглэлээр | | |
| 2.6.1 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны норм нормативыг тусгасан түгээмэл багц, иж бүрэн стандартыг боловсруулж батлуулах | НХХЯ, салбарын яамд | 2008-2010 |
| 2.7 | Чанар, аюулгүй байдлын мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр | | |
| 2.7.1 | Стандартын мэдээлэл, лавлагааны төвийн байрны нөхцөлийг сайжруулах, өргөтгөх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | СХЗТ | 2008-2010 |
| 2.7.2 | Стандарт, техникийн зохицуулалтын мэдээллийг online-аар хүргэх, "нэг цонх"-ны үйлчилгээнд шилжүүлэх, холбогдох боловсон хүчнийг бэлтгэх | СХЗТ | 2008-2009 |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 267 | Улаанбаатар хот

**Хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор батлагсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох яам, байгууллагын оролцоотойгоор батлан хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж явц, үр дүнг 2 жил тутам Засгийн газарт танилцуулж байхыг Байгаль орчны сайд Г.Шийлэгдамбад үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах, олон улсын байгууллага, хандивлагчдын зээл тусламжид хамруулах арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны сайд Г.Шийлэгдамба, Сангийн сайд Ч.Улаан нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД Г.ШИЙЛЭГДАМБА

Засгийн газрын 2008 оны 267 дугаар тогтоолын хавсралт

## АГНУУРЫН ЗАГАС ХАМГААЛАХ, ӨСГӨН ҮРЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг. Ерөнхий зүйл

Манай оронд 11 овгийн 74 зүйл загас амьдардгаас 30 гаруй зүйл нь агнуурын ач холбогдолтой юм. Амьтны аймгийн тухай хуулиар шивэр хилим, хар мөрний хилим, тул, ухэрдэй, зантаахай зэрэг 6 зүйл загас нэн ховор амьтны жагсаалтад орсон бол Засгийн газрын 2001 оны 264, 2005 оны 248 дугаар тогтоолоор цагаан амар, давх, тул зэрэг 3 зүйл загас ховор амьтны жагсаалтад орсон байна.

Манай улсад бүртгэгдсэн нийт загасны дөрөвний нэг орчим нь үндэсний хэмжээнд ховордож байгаа тухай Монгол орны загасны хамгааллын төлөвлөгөөний эмхтгэл баримт бичигт тэмдэглэжээ.

Үйлдвэрлэлийн зориулалтаар хөлдүү загас бэлтгэж, гадаадад гаргадаг явдлыг хязгаарлах замаар загасыг дотооддоо боловсруулж, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэхэд загасны аж ахуйн үйл ажиллагааг чиглүүлэх шаардлагатай байна. Үйлдвэрлэлийн зориулалтаар загас барихдаа юуны өмнө судалгаа, шинжилгээний ажил явуулж, загас агнуур явуулах нуурын нөөцийг зөв тогтоох, агнуурын загасны зүйл тус бүрээр барьж ашиглаж болох биеийн хэмжээ, түүнд тохирсон торны стандарт гаргах, загас агнуур зохион байгуулахтай уялдуулж Ан агнуурын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, загас үржүүлгийн ажлын техник, тоног төхөөрөмжийн хангалт, технологийн шийдэл, боловсон хүчний чадавхийг сайжруулахад анхаарна.

Агнуурын загасны хорогдлын үндсэн шалтгаан нь худалдааны зорилгоор хууль бусаар агнах, алт олборлолт болон бэлчээрийн талхагдлаас үүсэх тунадасжилт, алт олборлолтын явцад ашигласан хүнд металлаас үүсэх органик бохирдлын улмаас амьдрах орчны доройтол, хомсдоос үүдэлтэй байна. Хулгайн загасчид агнуурын загасны өвөлжих, хаваржих цунхэл гүн газрыг хөндөн сүйтгэж, хайр гамгүй агнасаар байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт "Монгол орны экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахад онцгой үүрэг бүхий амьтан, ургамлын зүйлийг судлах, сэргээн нутагшуулах, тарималжуулах ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөж хэрэгжүүлнэ" гэж заасан.

Иймд агнуурын загасыг хамгаалах, үржүүлэх замаар тогтвортой популяцийн бүтцийг бий болгох, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, гол мөрөн, нуурын ай савыг хамгаалах оновчтой менежмент хийх шаардлага тулгарч байна.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

2.1. Монгол орны агнуурын загасны нөөцийг хамгаалах, хэвийн өсөлтийг хангахын тулд загас агнуурын зохион байгуулалт менежментийн ажлыг шинэ шатанд гаргаж, цэнгэг усны загасыг өсгөн үржүүлэх, загасан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Зорилт:

2.2.1. агнуурын загас өсгөн үржүүлэх ажлын эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

2.2.2. агнуурын загасны нөөц байршлын судалгаа, мониторингийн ажлыг тогтмол зохион байгуулах;

2.2.3. агнуурын загас хамгааллыг сайжруулах арга замыг тодорхойлох, хойд мөсөн далай, номхон далай, төв Азийн гадагш урсгалгүй гурван ай сав газрын агнуурын загасны нөөцийн тогтвортой ашиглалтын менежментийг боловсруулж, хэрэгжүүлэх;

2.2.4. агнуурын загасны зүйл тус бүрээр барьж ашиглаж болох загасны биеийн хэмжээ, түүнд тохирсон торны стандарт гаргах.

2.3. Хөтөлбөрийг 2008-2015 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.1. Агнуурын загас өсгөн үржүүлэх ажлын эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:

3.1.1. зарим гол, мөрөн, нуурын ай сав газрыг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтад оруулах;

3.1.2. хууль бус загас агнуур, худалдааг таслан зогсоох эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

3.1.3. биологийн төрөл зүйлийг хамгаалах олон улсын конвенц болон бусад гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийг биелүүлэх механизмыг боловсронгуй болгох;

3.1.4. загас хамгаалах, үржүүлэх ажилд мэргэжлийн чиглэлийн төрийн бус байгууллагыг татан оролцуулах эрх зүйн орчин бүрдүүлэх;

3.1.5. манай оронд байдаггүй зүйл загасыг Монгол орны нуур, голд нутагшуулахгүй байх бодлогыг баримтлах;

3.1.6. хүний хууль бус үйл ажиллагаанаас үүсэх орчны бохирдол, нөлөөллийг хянах чиглэлээр олон улсын жишиг туршлагыг судлах, төлбөр тооцох эрх зүйн орчинг бий болгох.

3.2. Агнуурын загасны нөөц, байршлын судалгаа, мониторингийн ажлыг тогтмолжуулах зорилтын хүрээнд:

3.2.1. агнуурын загасны төрөл зүйлийн ашиглалтын нөөцийг судлан тогтоох ажлыг өргөжүүлэх;

3.2.2. агнуурын загас хамгаалах чиглэлээр үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, зөвлөлгөөн, уулзалт зохион байгуулах;

3.2.3. загас агнуур, нөхөн сэргээх, худалдаалахтай холбогдсон мэдээллийн санг бий болгох;

3.2.4. агнуурын загасны үржлийн нутгуудыг тогтоож, түүнийг хамгаалах арга хэмжээ авах.

3.3. Загас хамгааллыг сайжруулах арга замыг тодорхойлох зорилтын хүрээнд:

3.3.1. хууль бус загас агнуур, худалдааг таслан зогсоох зорилгоор хяналт шалгалтын ажлын менежментийг шинэ түвшинд гаргах;

3.3.2. загас үржүүлэг болон цөөрмийн аж ахуйд шаардагдах боловсон хүчний чадавхийг дээшлүүлж материаллаг баазыг сайжруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамруулах;

3.3.3. спорт загасчлал, загас барих байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх;

3.3.4. агнуурын загасыг хамгаалах ажилд орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

3.3.5. агнуурын загасны нөөцийг хамгаалахтай холбогдсон сургалт, сурталчилгааны ажлыг өргөжүүлэх замаар иргэд, холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэдээллээр хангах;

3.3.6. агнуурын загасны үржлийн нутгийг хамгаалах, үржлийн нутаг дахь байгалийн нөөцийн ашиглалтын ажлыг тодорхой хугацаанд зогсоох арга хэмжээ авах.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага удирдан зохион байгуулна. Шаардлагатай үед тодорхой асуудлаар төрийн бус байгууллага бусад төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажлын хэсэг зохион байгуулж болно.

4.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад 2 жил тутам хяналт шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг тодотгон ажиллана.

Тав. Санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

5.1.1. төсөв;

5.1.2. байгаль хамгаалах сан;

5.1.3. гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн тусламж, хандив;

5.1.4. бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

6.1. Агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр:

6.1.1. агнуурын загасны популяцийн бүтэц эрүүлжиж, байгалийн жамаар өсч үржих нөхцөл бүрдэж, гол, мөрөн, нуурын ай сав газрын экологийн тэнцвэр хадгалагдана;

6.1.2. агнуурын загасыг хамгаалахад нутгийн иргэд, төрийн бус байгууллагын оролцоо, сонирхол нэмэгдэж, орхийн орлогын шинэ эх үүсвэр бий болж, хамгааллын түвшин сайжирна;

6.1.3. орон нутагт загас агнуурын хугацаанд эргүүл-хяналтын ажлыг санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдсэнээр хууль бус агнуур, худалдаа эрс буурна;

6.1.4. агнуурын загасны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх, зүй зохистой ашиглах талаар олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүрэг биелэгдэж үндэсний эрх ашиг хангагдана;

6.1.5. спорт загасчлал хөгжиж, томоохон хот, суурин газрын дэргэд хиймэл усан санд агнуурын загасыг зориудаар үржүүлэх ажлын эхлэл тавигдана;

6.1.6. загасны гаралтай бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдэж, үндэсний болон экспортын үйлдвэрлэл хөгжинө;

6.1.7. агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглахтай холбогдсон эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн уялдаа сайжирч, судалгааны ажлын үр дүн үйлдвэрлэлд нэвтэрнэ;

6.1.8. агнуурын загасны үржлийг дэмжсэнээр экосистемд хүний үйл ажиллагааны улмаас нөлөөлж байгаа сөрөг нөлөөлөл буурна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 06 дугаар сарын 25-ны өдөр** **Дугаар 270** **Улаанбаатар хот**

**Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх объектын жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2004 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 135 дугаар тогтоолын хавсралтын нэг дэх хэсэгт "9. Улаанбаатар, Чойбалсан хотын усан хангамжийн эх үүсвэр" гэж нэмсүгэй.

2. Мөн хавсралтын хоёр дахь хэсгийн 1 дэх заалтаас "Улаанбаатар, Чойбалсан" гэсэн хэсгийг хассугай.

3. Улаанбаатар хот, Дорнод аймгийн Чойбалсан хотын ус хангамжийн эх үүсвэрийг Дотоодын цэргийн төсөвт хамгаалалтад шилжүүлсэнтэй холбогдуулан эдгээр объектын хамгаалалтын зардалд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байх, Дорнод аймгийн Чойбалсан хотын ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалах Дотоодын цэргийн 9 албан хаагчийн 2008 оны сүүлийн хагас жилд шаардагдах хөрөнгийг 2008 оны Монгол Улсын төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргил нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.МӨНХ-ОРГИЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр** **Дугаар 284** **Улаанбаатар хот**

**Үйл ажиллагааны чиглэл батлах тухай**

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Улсын Их Хурлын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-д хүүхэд, өсвөр үеийнхний хөгжил, хамгааллыг сайжруулах талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн зорилтыг хангах гурав дахь шатны үйл ажиллагааны чиглэлийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Үйл ажиллагааны чиглэлд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2009 оны үндсэн чиглэл, төсөвт тусган хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахын зэрэгцээ хөтөлбөрийн үр дүнд нэгдсэн хяналт-шинжилгээ хийхэд шаардагдах хөрөнгийг 2009 оны төсвийн багцдаа тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД М.ЭНХБОЛД**

Засгийн газрын 2008 оны 284 дүгээр
тогтоолын хавсралт

### ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (2002-2010)-ИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ГУРАВ ДАХЬ ШАТ (2008-2009)-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

| № | Бүрэлдэхүүн хэсэг, хэрэгжүүлэх зорилт, үйл ажиллагааны төрөл | Хугацаа | Хариуцах, хамтран хэрэгжүүлэх, дэмжих байгууллага |
|---|---|---|---|
| | Бүрэлдэхүүн хэсэг I. Хүүхдэд ээлтэй эрх зүйн шинэтгэл | | |
| | Зорилт 1. Хүүхдийг дээдлэх зарчимд нийцүүлэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох | | |
| 1 | Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, түүний нэмэлт протоколууд болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний зарчимд нийцүүлэн Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх замаар хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр тодорхой санал боловсруулах | 2008-2009 | ХТҮГ, ТББ, ОУБ |
| 2 | Гэр бүл, хүүхдийн асуудлаар мэргэшсэн шүүгч, дагнасан шүүх байгуулах асуудлыг судалж санал боловсруулах | 2009 | ХТҮГ, ХЗДХЯ, ХЭҮК, |
| 3 | Үндэсний бодлого, хөтөлбөрүүд тэдгээрийн хэрэгжилтэд нэгдсэн дүн шинжилгээ хийх замаар хүүхдийн эрх ашгийг хүндэтгэсэн цогц бодлого боловсруулахад баримтлах чиглэл, зарчмыг тодорхойлох | 2009 | НХХЯ, ХТҮЗ, ХТҮГ, ТББ, ОУБ |
| 4 | Хүүхдийг дотоод, гадаадын иргэнд үрчлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх | 2008-2009 | НХХЯ, ХЗДХЯ, ХТҮЗ |
| 5 | Хүүхдийн хамгаалагдах эрхийг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын чиг үүргийг нарийвчлан тогтоох | 2008-2009 | НХХЯ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ОУБ |
| 6 | Цэргийн сургуульд суралцаж байгаа 18 нас хүрээгүй хүүхдүүдэд зориулан дотуур байр, сургалтын орчны талаар тусгай дүрэм боловсруулж, мөрдүүлэх | 2008-2009 | БХЯ,ХТҮГ, ОУБ |
| | Зорилт 2. Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хянана | | |
| 1 | Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2002-2010)-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, олон нийтэд тайлагнах | 2009 | ХТҮГ, яам, аймаг, нийслэлийн Засаг дарга, ОУБ, ТББ, |
| 2 | Үндэсний хөгжлийн цогц бодлогод суурилсан Хүүхдийн хөгжил, хамгааллыг хангах урт хугацаа (2010-2015-2021)-ны үндэсний хөтөлбөрийг боловсруулж батлуулах | 2009 | ХТҮГ, ХТҮЗ, холбогдох яам, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ОУБ |
| 3 | Төрийн мэдээллийн сангийн үйл ажиллагаатай уялдуулж хүүхдийн мэдээллийн нэгдсэн санг байгуулах асуудлыг шийдвэрлэх | 2008-2009 | ХТҮГ, холбогдох яам, ХТҮЗ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ҮСХ, ОУБ |
| 4 | Хүүхдийн эрхийн конвенц, түүний нэмэлт протоколуудын тайланг НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны хуралд хэлэлцүүлэхэд бэлтгэх, арга хэмжээ авч ажиллах | 2009 | ХТҮГ, ХТҮЗ, холбогдох яам, ТББ, ОУБ |
| 5 | Цагаачлалд оролцож байгаа хүүхдийн нөхцөл байдлыг улс, бүсийн түвшинд судлах, энэ талаар баримтлах чиглэл боловсруулах | 2008-2009 | ХТҮГ, ГХЯ, ХЗДХЯ, ОУБ |

| | | | |
|---|---|---|---|
| | Бүрэлдэхүүн хэсэг П. Хүүхдийн амьдралын эрүүл, аюулгүй орчин | | |
| | Зорилт 3. Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих, хамгаалах зохистой бүтэц, тогтолцоо бүрдүүлнэ | | |
| 1 | Хүүхдийн анагаахын хүрээнд хүний нөөцийн асуудлыг судалж хэтийн чиглэлийг боловсруулах | 2008-2009 | ЭМЯ, БСШУЯ, ОУБ |
| 2 | Эрүүл мэндийн чиглэлийн сургуулиудын хүүхдийн анагаах болон хүүхдийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийж шинэчлэх | 2009 | ЭМЯ, БСШУЯ, ОУБ |
| | Зорилт 4. Хүүхэд, өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ | | |
| 1 | Мянганы Хөгжлийн Зорилт 4–ийн хүрээнд "Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийг хангах стратеги"-ийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх | 2008-2009 | ЭМЯ, НХХЯ, СЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ОУБ |
| 2 | Тав хүртэл насны хүүхдийн амбулаторийн эмчилгээний эмийн зардлыг Эрүүл мэндийн даатгалаас олгох механизмыг судалж боловсруулах | 2009-2010 | ЭМЯ, НХХЯ, НДЕГ |
| 3 | Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн хэрэгжүүлэх | 2008-2009 | ЭМЯ, ТББ, ОУБ |
| 4 | Эцэг эхийн хараа хяналтааас гадна байгаа болон засаг захиргааны бүртгэлгүй хүүхдийг дархлаажуулалтад бүрэн хамруулах | 2008-2009 | ЭМЯ, НХХЯ, ОУБ, ХТҮГ, ТББ |
| 5 | Ерөнхий боловсролын сургуулиудыг эмч, эрүүл мэндийн ажилтнаар хангаж, үйл ажиллагааг нь удирдамж арга зүйгээр дэмжиж ажиллах | 2008-2009 | БСШУЯ, ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 6 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох судалгаа явуулах | 2009 | ЭМЯ, БСШУЯ, НХХЯ, ХТҮЗ |
| | Зорилт 5. Хүүхэд, өсвөр үеийнхний зохистой хооллолтыг дэмжиж, аюулгүй хоол хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ | | |
| 1 | Цэцэрлэг, яслийн хүүхдийн хоолны стандартыг хэрэгжүүлэхэд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх | 2008-2009 | БСШУЯ, УМХГ, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 2 | Эх, хүүхдийг хоол, тэжээлийн дутагдлаас сэргийлэхтэй холбогдуулан өрхийн хүнсний үйлдвэрлэлийг дэмжих | 2008-2009 | ХХААЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ |
| 3 | Нялхас, бага насны хүүхдийн хоол, тэжээлийн талаар баримтлах стратегийг боловсруулан хэрэгжилтийг хангах | 2008-2009 | ЭМЯ, НХХЯ, ХХААЯ УМХГ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Өсвөр насны хүүхдийн зохистой хооллолтын талаар зөвлөмж боловсруулж, сурталчлах | 2008-2009 | ЭМЯ, БСШУЯ, ТББ |
| | Зорилт 6. Хүүхэд, өсвөр үеийнхэн эсэн мэнд амьдрах, хөгжих орчин, нөхцөл бүрдүүлнэ | | |
| 1 | Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, орчны бохирдлоос сэргийлэх талаар хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан сургалт, сурталчилгааг өргөжүүлэх | 2008-2009 | БОЯ, БСШУЯ, ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ |
| 2 | Хүүхэд, өсвөр үеийнхнийг ахуйн болон зам, тээврийн ослоос сэргийлэх чиглэлээр нийгмийн түншлэлийг хөгжүүлэх | 2008-2009 | ЦЕГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, БСШУЯ, ЭМЯ, ТББ |
| 3 | Хүүхдийн байгууллагуудын стандартыг хүүхдийн эрхэд тулгуурлан шинэчлэх үйл ажиллагаагдэмжих | 2008-2009 | УМХГ, БСШУЯ, ЭМЯ, БХБЯ, СХЗТ, ХТҮГ, ТББ |
| | Зорилт 7. Хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлнэ | | |
| 1 | Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл аж төрөх зан үйлийн талаар суурь судалгаа хийх | 2008-2009 | ЭМЯ, ХТҮГ, БСШУЯ, ТББ |
| 2 | Хүүхэд, өсвөр үеийнхний дунд тохиолдож байгаа осол гэмтлийн талаар нэгдсэн судалгаа хийж, зөвлөмж боловсруулах | 2008-2009 | ЭМЯ, ОУБ |
| 3 | Өсвөр үеийнхнийг хорт зуршилд донтох болон бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ–оос сэргийлэх чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг эрчимжүүлж, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх | 2008-2009 | ЭМЯ, БСШУЯ, НХХЯ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, МҮОН-ийн радио, телевиз |
| 4 | Шаардлагагүй тарилгаас татгалзах зан үйлийг хэвшүүлэх үйл ажиллагаагөргөжүүлэх | 2008-2009 | ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ОУБ |
| 5 | Шинээр болон дахин сэргэж гарах халдварт өвчинтэй холбоотой эрүүл ахуй, ариун цэврийн зан үйлийг хэвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг өргөжүүлэх | 2008-2009 | ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ |
| | Бүрэлдэхүүн хэсэг Ш. Хүүхдийн чанартай боловсрол, төлөвшил | | |
| | Зорилт 8. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлж, сургалтын агуулга, арга, хэлбэрийг боловсронгуй болгоно | | |
| 1 | Хөдөөгийн баг, сум, төв, суурин газрын захын хороолол сургуулийн өмнөх боловсролын олон талт үйлчилгээг өргөжүүлэх | 2008-2009 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ОУБ |
| 2 | Ерөнхий боловсролын сургуулийн 6 настай сурагчдад сургалтын ээлтэй орчин бүрдүүлэх, эцэг эх, гэр бүл, олон нийтийн оролцоог дэмжих идэвх санаачилгыг өрнүүлэх | 2008-2009 | БСШУЯ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ |

| | | | |
|---|---|---|---|
| | Зорилт 9. Суурь боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэн, хүүхдийг сурч боловсрох тэгш боломжоор хангах, тэдэнд амьдрах арга ухаан, мэргэжлийн чиг баримжаа олгох ажлыг өргөжүүлнэ | | |
| 1 | Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн төвийн сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаанд хүүхдийн эрхэд суурилсан эрхийг нь хангасан ойлголт, хандлагыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа өргөжүүлэх | 2008-2009 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ХТҮГ, ТББ |
| 2 | Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн төвийн багш, сурагчдын үнэлгээний тогтолцоог (багшийн ажлын болон сурагчийн мэдлэгийн үнэлгээ) олон улсын түвшинд хүргэх ажлыг эрчимжүүлэх | 2008-2009 | БСШУЯ, ХТҮГ, ОУБ,ТББ |
| 3 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Үдийн цай, хоол"-ны хөтөлбөрийн хэрэгжилтийг чанаржуулах, цай, хоолны чанар, хангамж, хадгалалт зэрэгт олон нийтийн хяналтыг өргөжүүлэх | 2008-2009 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ОУБ |
| 4 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дохионы хэл, брайлын стандартуудыг боловсруулан хэрэгжүүлж биелэлтэд нь хяналт тавих | 2008-2009 | БСШУЯ, ТББ, ОУБ |
| | Зорилт 10. Сургууль, хичээлээс гадуурхи сургалт, чөлөөт цагийг өнгөрүүлэх нөхцөлийг сайжруулж, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэн дэмжих таатай орчин бүрдүүлнэ | | |
| 1 | Хүүхэд, өсвөр үеийнхний хөгжлийн төв, биеийн тамир, спортын танхим, талбай, соёлын төв болон ордон байгуулах, засварлах, ашиглахад хөрөнгө оруулалтын олон талт эх үүсвэр бий болгох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | 2008-2009 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ХТҮГ, СЯ,ТББ, ОУБ |
| 2 | Олон нийтийн болон хүүхдийн үүсгэл санаачилгын байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх арга зүйг боловсруулах | 2008-2009 | ХТҮЗ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ОУБ |
| 3 | Гэр бүл, хүүхдэд зориулсан амралт, сувиллын үйлчилгээг өргөжүүлэх, стандартад нийцсэн амралт, зуслангийн үйл ажиллагааг дэмжин урамшуулах | 2008-2009 | Аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ХТҮГ, ОУБ |
| 4 | Сум, сургуулийн номын сангийн фондыг нэмэгдүүлэх, үйлчилгээний нэр төрлийг олшруулж, хүртээмжийг сайжруулах | 2008-2009 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ОУБ |
| 5 | Ерөнхий боловсролын сургуулийн эрх зүйн хичээлийн хөтөлбөрийн агуулга, үр дүнгийн байдлыг үнэлж санал боловсруулах | 2009 | БСШУЯ, ХЗДХЯ, ХТҮЗ,ТББ, ОУБ |

| | | | |
|---|---|---|---|
| | Бүрэлдэхүүн хэсэг IY. Гэр бүлд түшиглэсэн хүүхэд хамгаалал | | |
| | Зорилт 11. Гэр бүлийн таатай орчин бүрдүүлэх, нийгмийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэх замаар хүнд нөхцөлд байгаа хүүхдийн аж байдлыг сайжруулна | | |
| 1 | Сум, хороо, багийн "Өрхийн амьжиргааг дэмжих зөвлөл"-ийн гишүүдийг "Өрхийг чадваржуулах стратеги"-ийн чадавхи бэхжүүлэх сургалтад хамруулах ажлыг бүсчлэн зохион байгуулах | 2008-2009 | НХХЯ, БХҮХАА, Бүсийн зөвлөлийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, ХТҮГ, ТББ, ОУБ |
| 2 | Хүүхдэд үзүүлж байгаа асрамж халамж, хамгааллын үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах | 2008-2009 | НХХЯ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ОУБ |
| 3 | Гэр бүл, нийгэм, хамт олонд түшиглэсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх, уг үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх | 2008-2009 | НХХЯ,ХТҮГ,ТББ аймаг, нийслэлийн Засаг дарга, ОУБ |
| 4 | Хүүхдийн ядуурал, ялгаатай байдлыг арилгах, түүнээс сэргийлэх арга хэмжээг үндэсний болон салбарын бодлогын баримт бичгүүдэд тусгах | 2008-2009 | НХХЯ,ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ОУБ |
| 5 | Хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх туршилтын сургалтын хөтөлбөр боловсруулах | 2008-2009 | НХХЯ, ХТҮЗ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ОУБ ТББ |
| | Зорилт 12. Хүүхдийг аливаа гэмт хэрэг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн болон түүнд холбогдсон насанд хүрээгүй хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэнэ | | |
| 1 | Цагдаагийн байгууллагын хүүхдийн асуудал эрхэлсэн нэгжийн ажилтнуудыг чадавхижуулах | 2008-2009 | ХЗДХЯ, ЦЕГ, ХТҮГ, ОУБ |
| 2 | Насанд хүрээгүй хүний эрхийг хүндэтгэх асуудлаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурор, өмгөөлөгч, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, орон нутгийн сургагчдыг давтан бэлтгэх сургалтыг үргэлжлүүлж, үнэлгээ өгөх | 2008-2009 | ХЗДХЯ, НХХЯ, ХТҮГ, ТББ, ОУБ |
| 3 | Иргэд, олон нийтийн зүгээс хүүхдийн эрхийн зөрчлийг холбогдох байгууллагад мэдээлдэг бүх тогтолцоог бий болгоход чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах | 2008-2009 | ХТҮГ, ТББ, Яамд, ҮСХ, ОУБ |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Хууль зөрчсөн аливаа үйлдэл болон гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллах чиглэл, аргачлал боловсруулж хэрэгжүүлэх | 2008-2009 | ХЗДХЯ, ЦЕГ, ХТҮГ, ТББ, аймаг, нийслэлийн Засаг дарга , ОУБ |
| 5 | "Хүн байхын учир" аяныг үргэлжлүүлж, энэ хүрээнд гэр бүл, хүүхдэд зориулсан эрх зүйн сургалт, мэдээллийг өргөжүүлэх | 2008-2009 | Аймаг, нийслэлийн Засаг дарга, ЦЕГ, ХТҮГ,ТББ, ОУБ |
| | Зорилт 13. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн ажлыг эрчимтэй зохион байгуулна | | |
| 1 | Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдэд нийслэлийн анхан шатны засаг захиргааны байгууллагын зүгээс үзүүлэх нийгмийн халамж үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох (боловсрол, эрүүл мэнд) | 2008-2009 | НХХЯ,ХТҮГ аймаг, нийслэлийн Засаг дарга, ОУБ |
| 2 | Бага болон өсвөр насны хүүхдийг бэлгийн мөлжлөгт татан оруулж байгаа байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тодорхойлох | 2008-2009 | ЦЕГ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ОУБ |
| 3 | Хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдал, эрхийг хамгаалах шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, дүнг холбогдох байгууллагад мэдээлэх | 2008-2009 | ХТҮГ, БТСУХ, аймаг, нийслэлийн Засаг дарга, Баяр наадмын комисс, ТББ, ОУБ |
| | Зорилт 14. Хүүхдийг байгалийн гамшиг, ган, зуд, үер ус, гал түймэр, халдварт өвчний тархалтаас хамгаалах үндэсний чадавхийг бэхжүүлнэ | | |
| 1 | Онцгой байдлын үед хүүхэд, өсвөр үеийг сэрэмжлэн хамгаалах стратеги боловсруулах, сурталчлах, хэрэгжүүлэх | 2008-2009 | ХТҮГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ОУБ |
| 2 | Онцгой байдлын үед хүүхэд, өсвөр үеийг хамгаалах, аврах чиглэлээр холбогдох ажилтнуудыг сургах сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | 2008-2009 | ОБЕГ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ОУБ |
| | Бүрэлдэхүүн хэсэг Ү. Хүүхэд, өсвөр үеийнхний оролцоо, мэдээллийн хүртээмж | | |
| | Зорилт 15. Хүүхдийн оролцоо, өөрийн удирдлагын байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон нийтийн хамтын үйл ажиллагааг хөгжүүлнэ | | |
| 1 | Хүүхдийн оролцооны тухай нийгмийн ойлголтыг гүнзгийрүүлэн зэрэг хандлагыг бий болгох үйл ажиллагааг үргэлжлүүлэх | 2008-2009 | ХТҮГ, ТББ, ОУБ |
| 2 | Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, сурагчдын зөвлөл, аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангахад техник арга зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлэх | 2008-2009 | ХӨУБ, ХТҮГ, ТББ, ОУБ, аймаг, нийслэлийн Засаг дарга |

| | | | |
|---|---|---|---|
| | Зорилт. 16. Хүүхэд, өсвөр үеийнхний эрхээ эдлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадварыг хөгжүүлнэ | | |
| 1 | Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх чиглэлээр олон нийтэд зориулан сургалт, сурталчилгаа явуулах | 2008-2009 | ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ОУБ |
| 2 | Хүүхэд, ялангуяа алслагдсан бүс нутгийн хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлэх боломж, нөхцөлөөр хангах | 2008-2009 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ХТҮГ, ТББ, ОУБ, БХҮХ |
| | Зорилт 17. Хүүхэд, өсвөр үеийнхэн мэдээллийг эрж хайх, сонгох, боловсруулах, ашиглах, түгээх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн төр, олон нийтийн дэмжлэгийг өргөжүүлнэ | | |
| 1 | Мэдээлэл ялангуяа цахим мэдээллийн сөрөг нөлөөнөөс сэргийлэх, хүүхдийг хамгаалах сурталчилгааг өргөжүүлэх | 2008-2009 | ХТҮГ, УМХГ, ТББ, ОУБ |
| 2 | Хүүхдийн болон хүүхдэд зориулсан уран бүтээлийг дэмжих, хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх | 2008-2009 | БСШУЯ, ХТҮЗ, ТББ |
| | Бүрэлдэхүүн хэсэг YI. Хүүхдийн төлөө байгууллагын үндсний чадавхи бүрдүүлэлт | | |
| | Зорилт 18. Хүүхдийн төлөө байгууллагын үндсний чадавхийг нийгмийн шаардлагад нийцүүлэн сайжруулна | | |
| 1 | Хүүхдийн төлөө байгууллагыг чадавхижуулах хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх | 2008-2009 | ХТҮГ, ХТҮЗ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ОУБ |
| 2 | Хүүхдийн эрхийг хамгаалах үе шаттай сургалтыг бүх шатны Засаг дарга нарт зориулан зохион байгуулах | 2008-2009 | ХТҮГ, ЗГХЭГ, ТББ, ОУБ |
| 3 | Салбарын бодлого, төлөвлөлт нь хүүхдэд мэдрэмжтэй байх шаардлагыг хангаж байх арга зүйн сургалт зохион байгуулах | 2008-2009 | ХТҮГ, ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ОУБ |
| 4 | Ажил олгогч бүхэн өөрсдийн ажилтнуудын хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлыг тогтмол хугацаанд хэлэлцдэг байхад чиглэсэн нөлөөллийн ажиллагаа явуулах | 2008-2009 | ТББ, ХТҮГ, БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 5 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх болон эдгээр хүүхэдтэй ажилладаг багш нарыг чадваржуулах сургалт зохион байгуулах | 2008-2009 | НХХЯ,БСШУЯ, ХТҮГ,ТББ, ОУБ |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 288 | Улаанбаатар хот

### Хөтөлбөр батлах тухай

Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах, ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг ахуйн үйлчилгээний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад жил бүр тусгахын зэрэгцээ Засгийн газрын холбогдох тусгай сан, сонирхогч орон, олон улсын байгууллагад санал болгон санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэл, Сангийн сайд Ч.Улаан нарт үүрэг болгосугай.

3. Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих дэд хөтөлбөрийг баталж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр орон нутгийн төсөвт тусгаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүүд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Х.НАРАНХҮҮ

Засгийн газрын 2008 оны 288 дугаар тогтоолын хавсралт

## АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Үндэсний статистикийн хорооны мэдээнээс үзэхэд өнөөгийн байдлаар ахуйн үйлчилгээний салбарын хэмжээнд нийт 219 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, 1200 гаруй хүнийг ажлын байраар хангаж байна. Монголын үйлдвэрлэлийн хоршоодын төв холбооноос 2007 онд хийсэн судалгаанаас үзэхэд ахуйн үйлчилгээний салбарт 60 гаруй мянган хүн ажиллаж байна. Албан ёсны статистик мэдээ болон албан бус мэдээлэл зөрүүтэй байгаа нь энэхүү салбарын үйл ажиллагааны 98 хувь нь албан бус хэвшилд хамрагдаж байгаатай холбоотой юм. Сүүлийн жилүүдэд ахуйн үйлчилгээний нэр төрлийн тоо олширч, нийгэм, эдийн засагт тодорхой нөлөө үзүүлж байна.

2. Салбарын хэмжээнд үүссэн нөхцөл байдлыг сайжруулах, үйлчилгээний нэр төрлийг олшруулах, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, үйлдвэрлэл, үйлчилгээний чадавхи, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

3. Хөтөлбөрийн зорилго нь Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд ахуй үйлчилгээний салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, ахуйн үйлчилгээний салбарын хөгжлийг дэмжих эрх зүй, эдийн засгийн орчныг бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын түншлэлийг бэхжүүлэх замаар хүний хөгжлийг дэмжих, үйлчилгээний хүртээмж, соёлыг дээшлүүлэхэд оршино.

4. Энэхүү зорилгыг дараахь зорилтоор хэрэгжүүлнэ:

4.1. ахуйн үйлчилгээний онцлогийг тусгасан салбарын хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчин бүрдүүлэх;

4.2. ахуйн үйлчилгээний салбар дахь хүний хөгжлийг дэмжих тогтолцоог боловсронгуй болгож, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

4.3. ахуйн үйлчилгээг бодлогоор дэмжиж, санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээг нэвтрүүлэх;

4.4. үйлчилгээг олон улсын чанар, стандартын түвшинд хүргэх, салбарын хэмжээнд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5. Ахуйн үйлчилгээний онцлогийг тусгасан салбарын хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.1. ахуйн үйлчилгээний чиглэлээрх төрийн бус байгууллагаар төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;

5.2. албан бус хэвшлээс албан хэвшилд шилжин орох ахуйн үйлчилгээ эрхлэгч иргэдийн санал санаачилгыг дэмжиж, нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх, энэ чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

5.3. тив, дэлхий, олон улсын хэмжээний мэргэжлийн уралдаан, тэмцээн, үзэсгэлэн яармагт оролцон өндөр амжилт үзүүлсэн ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг үнэлж, урамшуулах эрх зүйн орчин бий болгох;

5.4. төрийн өмчид шилжихээс өмнө хоршоологчдын хөрөнгөөр бий болгосон зарим барилга, байшинг Монголын үйлдвэрлэлийн хоршоодын төв холбоонд эзэмшүүлэх асуудлыг судалж санал боловсруулах;

5.5. ажлын байрны нөхцөл сайжруулах, шинээр баригдах барилгын нэгдүгээр давхрыг үйлчилгээний шаардлагад нийцүүлэн зураг, төсөв зохиох, барих санал, санаачилгыг урамшуулах асуудлыг судалж шийдвэрлэх;

5.6. ахуйн үйлчилгээний нэр төрөл бүрийн чиглэлээрх стандартыг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх.

6. Ахуйн үйлчилгээний салбар дахь хүний хөгжлийг дэмжих тогтолцоог боловсронгуй болгож, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

6.1. ажиллагсдын мэргэжлийн болон аж ахуй эрхлэх ур чадварыг тогтмол дээшлүүлэх, сургагч багш, олон улсын шүүгч, дасгалжуулагч бэлтгэх сургалтын тогтолцоог бий болгон хөгжүүлэх;

6.2. мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөр нарийн мэргэжлийн ажилчин сургаж бэлтгэх, залгамж чанарыг бий болгох;

6.3. хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн мэдээллийн нэгдсэн санд ахуйн үйлчилгээний төрлөөр дэд сан бий болгон хөгжүүлэх;

6.4. ахуйн үйлчилгээний нэр төрөл бүрээр "Мастер" цол олгох журмыг боловсронгуй болгох;

6.5. ахуйн үйлчилгээний нэр төрлийн ангиллыг боловсронгуй болгох, статистик бүртгэлийг бий болгон хөгжүүлэх.

7. Ахуйн үйлчилгээг бодлогоор дэмжиж, санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.1. ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор ахуйн үйлчилгээний чиглэлээр боловсруулсан эдийн засгийн үр ашиг бүхий төслийг шалгаруулж зээл олгоход дэмжлэг үзүүлэх;

7.2. аймгийн төв, нийслэлийн дүүргүүдэд зах зээлд өрсөлдөх, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх чадвар бүхий ахуйн үйлчилгээний цогцолбор байгуулах төсөл шалгаруулж, дэмжлэг үзүүлэх;

7.3. ахуйн үйлчилгээний салбарын хэмжээнд зээлийн баталгаа, даатгалын сан байгуулж, хөрөнгө оруулалт хийх боломжийг бий болгох, бүрдүүлэх;

7.4. салбарын үйл ажиллагаатай холбогдолтой шинэ техник, технологийн мэдээллийн сүлжээ бий болгож, санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх.

8. Үйлчилгээг олон улсын чанар, стандартын түвшинд хүргэх, салбарын хэмжээнд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

8.1. тив, дэлхий, бүсийн хэмжээнд хамтын ажиллагаа явуулах чиглэлээр харилцан туршлага солилцох, үзэсгэлэн яармаг, уралдаан тэмцээнд оролцох;

8.2. хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг уялдуулах;

8.3. салбарын хэмжээнд байгуулсан тарифын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд бүх талаар дэмжиж ажиллах, шинээр дэд салбарт тарифын хэлэлцээр байгуулах чиглэлээр хамтран ажиллах.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хугацаа

9. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, уялдуулан зохицуулах, хяналт тавих үүргийг Үндэсний зөвлөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ өгөх, тайлагнах үүргийг ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

10. Үндэсний зөвлөл нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.1. хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих;

10.2. хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн дүгнэх;

10.3. ахуйн үйлчилгээний салбарын гадаад харилцааг өргөжүүлж, ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг олон улсын түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэх.

11. Хөтөлбөрийг дараахь эх үүсвэрээр санхүүжүүлнэ:

11.1. улсын болон орон нутгийн төсөв;

11.2. Засгийн газрын холбогдох тусгай сангийн хөрөнгө;

11.3. олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөр;

11.4. банкны зээл, хувийн хөрөнгө оруулалт.

12. Хөтөлбөрийг 2008–2016 онд хэрэгжүүлнэ.

Тав. Үр дүн

13. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

13.1. ахуйн үйлчилгээ эрхлэх эрх зүй, нийгэм, эдийн засгийн таатай орчин бүрдэнэ;

13.2. ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэж, ажилгүйдэл, ядуурал буурч, амьдралын түвшин дээшилнэ;

13.3. ахуйн үйлчилгээний чанар сайжирч, хүртээмж, нэр төрөл нэмэгдэнэ;

13.4. ажиллагсдын ур чадвар, өрсөлдөх чадвар дээшилнэ.

Зургаа. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

14. Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

14.1. Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд дэвшүүлсэн ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого болон боловсрол, хүний хөгжил, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын үр дүнгийн тайлан, түүнд хийсэн шинжилгээ;

14.2. ахуйн үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан сургалт, зөвлөгөө, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, чанар, түүний үр нөлөө, мэдээ, мэдээлэл дамжуулах төвийн тоо, тэдгээрийн үр дүн, төрийн бус байгууллага, иргэдийн оролцооны өсөлт;

14.3. ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн тоо болон тэдгээрийн үйлдвэрлэл, үйлчилгээний өсөлт, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, түүний өсөлт, хөгжлийн сан, арилжааны банкнаас олгосон зээл, түүний үр дүн, гадаадын зээл, тусламжийн өсөлт, түүний үр дүн, шинээр бий болгосон ажлын байрны тоо.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр** | **Дугаар 289** | **Улаанбаатар хот**

### Үндэсний хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай

"Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт" болон "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-д тусгагдсан ХДХВ/ДОХ өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх тухай зорилтуудыг хэрэгжүүлэх, ХДХВ/ДОХ-оос сэргийлэх Үндэсний стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх ажлыг нэгдсэн бодлого, зохицуулалтаар хангах, салбар хоорондын үйл ажиллагаа, оролцоог чиглүүлэх үүрэг бүхий "ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах Үндэсний хороо"-ны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, Үндэсний хорооны дүрмийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, эмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, гадаад орон, олон улсын байгууллага, иргэдийн дэмжлэг, оролцоонд түшиглэн зохион байгуулж, үр дүнг жил бүр Засгийн

газарт танилцуулж ажиллахыг Үндэсний хороонд үүрэг болгосугай.

3. "ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах Үндэсний хороо"-ны үйл ажиллагааны зардлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолын 17 дугаар хавсралтын 42 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД Ч.УЛААН

**Засгийн газрын 2008 оны 289 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт**

**ХДХВ/ДОХ-ООС СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

**Дарга** - Монгол Улсын Шадар сайд

**Орлогч дарга** - Эрүүл мэндийн сайд

**Гишүүд:** - Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд;

-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч;

-Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр);

-Цагдаагийн ерөнхий газрын дарга;

-Улсын гаалийн ерөнхий газрын дарга;

-Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга;

-Хил хамгаалах ерөнхий газрын дарга;

-Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн дарга;

-Засгийн газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга;

-Хүүхдийн төлөө Үндэсний газрын дарга;

-Монголын улаан загалмайн нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн дарга (тохиролцсоноор);

-ДОХ-той тэмцэх Үндэсний сангийн ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-МҮЭ-үүдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Монголын эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор).

**Нарийн бичгийн дарга** - Үндэсний хорооны Ажлын албаны дарга

Засгийн газрын 2008 оны 289 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

## "ХДХВ/ДОХ-ООС СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРОО"-НЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах Үндэсний хороо /цаашид энэ дүрэмд "Үндэсний хороо" гэх/ нь хүний дархлал хомсдолын вирус /ХДХВ/ болон дархлалын олдмол хомсдол /ДОХ/-оос сэргийлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд уялдуулан зохицуулах үүргийг гүйцэтгэх бөгөөд яамд, холбогдох бусад байгууллагуудын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг чиглүүлж ажиллана.

1.2. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх талаархи хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж хяналт тавих, хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх талаар төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг туслалцаа үзүүлэх нь Үндэсний хорооны зорилго байна.

1.3. Үндэсний хороо нь ажлаа Засгийн газарт тайлагнаж, түүний өмнө хариуцлага хүлээнэ.

1.4. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх ажлыг аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий аймаг, нийслэлийн салбар зөвлөл ажиллана. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга батална.

1.5. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх асуудлаар үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааны уялдааг хангах үүрэг бүхий яамны салбар зөвлөлийг байгуулж ажиллана. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн ажлыг эрхэлсэн сайд батална.

1.6. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийг Үндэсний хороо батална.

Хоёр. Үндэсний хорооны удирдлага, ажлын зохион байгуулалт

2.1. Үндэсний хороо нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

2.2. Үндэсний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Үндэсний хорооны хуралдааныг жилд 2 удаа зохион байгуулах бөгөөд хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг ажлын алба төлөвлөж, бэлтгэл ажлыг хангана. Шаардлагатай бол Үндэсний хорооны даргын шийдвэрээр ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

2.3. Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар тогтоол, тэмдэглэл, зөвлөмж гаргана. Үндэсний хороо нь шаардлагатай бол асуудал боловсруулж Засгийн газрын хуралдаанд зохих журмын дагуу оруулж шийдвэрлүүлж болно.

2.4. Үндэсний хорооны гишүүдийн олонхи нь оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болно. Хуралдааныг Үндэсний хорооны дарга, түүний эзгүйд Үндэсний хорооны орлогч дарга удирдан явуулна.

2.5. Үндэсний хороо нь албан бичгийн хэвлэмэл хуудас, зохих журмын дагуу хийгдсэн тэмдэг хэрэглэнэ.

2.6. Үндэсний хорооны өдөр тутмын ажлыг Ажлын алба гүйцэтгэнэ.

2.7. Ажлын алба Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг боловсруулан шаардлагатай бусад материалыг авч эцэслэн хянаж, хуралдаанд оруулах саналыг Үндэсний хорооны даргад танилцуулан хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гаргаж хурал эхлэхээс 7 хоногийн өмнө гишүүдэд тараана.

2.8. Ажлын албаны дарга нь Үндэсний хөтөлбөрийн ерөнхий зохицуулагч байна.

2.9. Ажлын албаны дарга бөгөөд Үндэсний хөтөлбөрийн ерөнхий зохицуулагч нь Ажлын албыг өдөр тутмын удирдлагаар хангаж, Үндэсний хорооны нарийн бичгийн даргын ажлыг давхар гүйцэтгэнэ.

2.10. Үндэсний хорооны дарга Ажлын албаны дүрмийг баталж, албаны даргыг томилж, чөлөөлнө.

2.11. Үндэсний хорооны гишүүдийн ажил, үүргийн хуваарийг Үндэсний хорооны дарга батална.

Гурав. Үндэсний хорооны эрх, үүрэг

Үндэсний хороо нь дараахь эрхийг эдэлнэ:

3.1. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх

тухай Монгол Улсын хууль, дархлалын олдмол хомсдолын холбогдох хөтөлбөрүүд болон ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үндэсний стратегийг хэрэгжүүлэх ажилд холбогдох байгууллагуудыг хүлээсэн чиг үүргийн дагуу татан оролцуулах;

3.2. Шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;

3.3. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийг зөрчсөн байгууллага, хувь хүмүүст хариуцлага хүлээлгэх талаар хууль хяналтын байгууллагад санал гаргах;

3.4. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх ажлын хүрээнд зохиогдох аливаа арга хэмжээг төлөвлөх, батлах, гүйцэтгэгчийг томилон ажиллуулах, энэ талаар шийдвэр гаргуулахаар холбогдох байгууллагад уламжлах;

3.5. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгжийг татан оролцуулах арга хэмжээ авах;

3.6. Яам, аймаг, нийслэлийн салбар зөвлөлийн илтгэл сонсголыг хэлэлцэж удирдамж, чиглэл өгөх, холбогдох байгууллагын үйл ажиллагаатай танилцаж чиглэл, зөвлөгөө өгөх;

3.7. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх чиглэлээр дотоод, гадаадын болон олон улсын байгууллага, иргэдтэй хамтран ажиллах;

3.8. Үндэсний хороо түүний Ажлын албаны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хэлэлцэн батлах.

Үндэсний хороо нь дараахь үүргийг гүйцэтгэнэ:

3.9. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үндэсний бодлого, стратегийг боловсруулах, салбар хоорондын болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэмжлэг үзүүлэх;

3.10. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үндэсний бодлого, стратегийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.11. ХДХВ/ДОХ-ын тархалтын нөхцөл байдлын талаар Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулж холбогдох шийдвэр гаргуулах;

3.12. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үндэсний бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох, төсөвт тусгуулах, гадаад, дотоодын хандивлагчдын тусламж, дэмжлэг болон санхүүжилтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

3.13. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үндэсний чадавхийг сайжруулах арга хэмжээ авах;

3.14. Үндэсний хороо түүний Ажлын албаны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж мөрдөх;

3.15. Үндэсний хороо түүний Ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой зардлын төсвийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсөвт зохих журмын дагуу тусгуулж байх;

3.16. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үндэсний стратеги, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, батлагдсан төсвийн зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр дүгнэж Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцэн, Засгийн газарт тухай бүр тайлагнаж байх.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 07 дугаар сарын 16-ны өдөр** | **Дугаар 290** | **Улаанбаатар хот**

**2008-2009 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай**

2008-2009 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2008-2009 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг зохицуулж, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, аймаг, нийслэлийн хэмжээнд 2008 онд бэлтгэх хадлан, тэжээлийн даалгаврыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батлсугай.

2. Улс, аймаг, сумын хадлангийн нөөц газруудаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хуваарилан хадлан бэлтгүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Цолмон, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Улсын нөөцийн өвс, тэжээлийг тухайн аймаг, бүсээс бэлтгэх замаар орон нутаг дахь улсын

нөөцийн цэг, салбар болон аймаг дундын отрын бүс нутагт өвс, тэжээлийн нөхөн бүрдүүлэлт хийж, зохих газарт нь байршуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод үүрэг болгосугай.

4. Улсын нөөцийн өвс, тэжээлийн цэг, салбарын байршлыг өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан зохицуулж өвс, тэжээл нэмж бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2008 оны Монгол Улсын төсвийн тухай хуульд нэмэлт оруулах замаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

5. Түлш, эрчим хүчний үйлдвэр, сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон зам, тээвэр, харилцаа холбоо, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гарган биелэлтэд нь хяналт тавьж ажиллан, бүх шатны сургуулийн хичээлийн болон дотуур байр, цэцэрлэгийн барилгын засвар, өргөтгөлийг хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө дуусгах арга хэмжээ авахыг Түлш, эрчим хүчний сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Эрүүл мэндийн сайд Д.Батсэрээдэнэ, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Р.Раш, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Цолмон нарт тус тус үүрэг болгосугай.

6. Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийн 2008-2009 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд хийгдэх үндсэн болон туслах тоноглолын засварыг графикт хугацаанд нь чанартай хийж, нүүрс, мазут нийлүүлэх, тээвэрлэх, нөөцлөх ажлыг эрчимжүүлэн 2008 оны 10 дугаар сарын 1-ний дотор 20-иос доошгүй хоногийн нөөцтэй болгох арга хэмжээ авахыг Түлш, эрчим хүчний сайд Ч.Хүрэлбаатар болон Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд даалгасугай.

7. "Багануурын дулааны станц" ХК-ийн 2008-2009 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд зайлшгүй хийгдэх зуухны их засвар, техникийн шинэчлэлт, бага ачааллын үед ажиллах зуух, түлш дамжуулах цехийн ремен солих зэрэг ажлыг гүйцэтгэх болон тус станцын үйл ажиллагааны алдагдлыг нөхөхөд шаардагдах хөрөнгийн асуудлыг судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Улаан, Түлш, эрчим хүчний сайд Ч.Хүрэлбаатар болон Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд даалгасугай.

8. "Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг сайжруулах II шатны төсөл"-ийн хүрээнд зарим аймгуудад хэрэгжиж байгаа халаалтын зуухыг шинэчлэх ажлын чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллан халаалтын улирал эхлэхээс өмнө ашиглалтад оруулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Цолмонд үүрэг болгосугай.

9. 2008-2009 оны хичээлийн жилээс 6 настай хүүхдийг элсүүлэн суралцуулахтай холбогдуулан хийх засварын ажлыг батлагдсан төсөвтөө багтаан 8 дугаар сарын 25-ны дотор чанарын өндөр түвшинд хийж дуусгахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

10. Аймгийн Засаг дарга нараас тавьсан хүсэлтийн дагуу мэргэжлийн ажлын хэсэг томилон ажиллуулж зуншлагын байдал, өвөлжилтийн бэлтгэл ажлын явцтай газар дээр нь танилцан холбогдох арга хэмжээ авахын зэрэгцээ отрын болон хадлангийн газрын нөөц, ашиглалтын талаар судалгаа хийж малын отор нүүдлийн нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт хийх талаар санал боловсруулж 2008 оны 8 дугаар сарын 15-ны дотор Засгийн газарт танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Байгаль орчны сайд Г.Шийлэгдамба нарт даалгасугай.

11. Ургац хураалтын тээвэрт ашиглагдах зам, гүүрийн шинэчлэлт, засварын ажлыг яаралтай эхлүүлэн чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Р.Раш, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг нарт даалгасугай.

12. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Р.Рашид үүрэг болгосугай:

а) цаг агаарын хүндрэлтэй үед улсын чанартай авто зам, замын байгууламжид эвдрэл гарч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулах явдлаас урьдчилан сэргийлэх, авто тээврийн хэрэгсэл саадгүй нэвтрэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор авто замын засвар арчлалтын ажлын чанарыг сайжруулан тогтмолжуулах, гэнэтийн эвдрэлийг шуурхай засварлаж байх арга хэмжээ авах;

б) төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэн тодорхой нөөцтэй байлгах, засвар, үйлчилгээг хугацаанд нь чанартай хийх.

13. Нүүрсний уурхай, дулааны цахилгаан станцуудын хооронд үүссэн өр, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Ч.Улаан, Түлш, эрчим хүчний сайд Ч. Хүрэлбаатар нарт даалгасугай.

14. Улаанбаатар хот болон томоохон хот, суурин газруудад махны худалдааны төв, аймгуудын төвийн орчимд "Мал, махны бирж" байгуулах асуудлыг судалж шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, Үйлдвэр,

худалдааны сайд Х.Наранхүү, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

15. Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор "Махны нөөцийн сан" бий болгох талаар санал боловсруулан 2008 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, Сангийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

16. Бензин, шатахууны 2 сарын хэрэглээтэй тэнцэх хэмжээний нөөцийг бүрдүүлэх талаар гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж шаардагдах хөрөнгийн асуудлыг шуурхай шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү нарт даалгасугай.

17. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуягт даалгасугай:

а) өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, цаг хүндэрсэн үед ажиллуулах шуурхай ажлын штаб байгуулах асуудлыг урьдчилан зохицуулж, шаардлагатай арга хэмжээг тухайн үед нь холбогдох яам, газар, аймаг, нийслэлийн захиргааны байгууллагатай хамтран шийдвэрлэх;

б) ургац хураалтын бэлтгэл ажлыг урьдчилан сайтар хангаж, технологийн хугацаанд нь хаягдалгүй хураах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах;

в) дараа оны тариалалтад хүрэлцэхүйц хэмжээний чанар сайтай үрийн буудайг нөөцлүүлж, өмнөх онуудад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зээлээр олгосон үрийн будаа, техник, тоног төхөөрөмжийн төлбөрийн үнийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулах.

18. Дор дурдсан арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:

а) энэ тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан 2008 онд бэлтгэх хадлан, тэжээлийн даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулах;

б) орон нутгийн эрчим хүчний үйлдвэр, нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өвлийн бэлтгэлийг хангуулах, түлээ, нүүрс нөөцлөх, түлш, шатахуун татан авах зэрэг ажлыг зохион байгуулж энэ оны 10 дугаар сарын 1-ний дотор нүүрс, шатахуун, дизелийн түлшний 20-иос доошгүй хоногийн нөөцийг бүрдүүлж, төв, суурин газрын барилга байгууламж, орон сууцны цэвэр, бохир ус, дулааны шугам хоолойн ээлжит засвар, үйлчилгээ, угаалга, туршилт, авто зам, харилцаа холбооны шугамын арчлалт, үйлчилгээг төлөвлөсөн хугацаанд нь хийж дуусгах арга хэмжээ авах;

в) нийтийн тээврийн хэрэгсэл, тэдгээрийн гаражийн засвар, дулаалгыг хугацаанд нь чанартай хийж, сэлбэг хэрэгсэл, өвлийн улирлын шатахуун, тослох материалыг зохих хэмжээнд нь нөөцөлж иргэдэд найдвартай үйлчлэх нөхцөл бүрдүүлэх;

г) нутаг дэвсгэрийнхээ зуншлага, намаржилтын байдалтай уялдуулан мал өвөлжүүлэх, отор нүүдэл хийх, хадлангийн газрын ашиглалтын төлөвлөгөө, зураглал гарган шаардлагатай үед нөөц бэлчээрийг ашиглах талаар гэрээ байгуулах ажлыг эртнээс зохицуулан зохион байгуулах;

д) аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бий болгон шаардлагатай цэгүүдэд байршуулах арга хэмжээ авах;

е) улсын төсвийн хөрөнгөөр олгож байгаа эм, бэлдмэлийг сум, дүүрэгт хүргэн малын туулга, угаалгын ажлыг 10 дугаар сарын 1-ний дотор дуусгах ажлыг зохион байгуулах;

ж) тариаланг малаас хамгаалах зорилгоор мал бүхий иргэдийг тариалангийн нутагт түр хугацаагаар нутаглуулахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах;

з) тариалан бүхий аймаг, сумдын шатахууны нөөц, савны дүүргэлтэд анхаарч, үрийн боловсруулалт, ургац хураалтын ажилд шаардагдах шатахууныг тасалдуулахгүй байх зохицуулалт хийж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

к) цаг агаарын гамшигт үзэгдлийн улмаас зүүн аймгийн малгүй болж амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой болсон сумдын зарим малчдыг малжуулах талаар санал боловсруулах;

л) өвөлжилтийн бэлтгэл ажилд иргэд, малчид, аж ахуйн нэгж, байгууллагын хүч анхаарлыг төвлөрүүлэх зорилгоор орон нутагт зохион байгуулах найр, наадмыг хязгаарлах арга хэмжээ авах;

м) сум, баг, дүүргийн өвөлжилтийн бэлтгэл ажлын явцыг шалган үр дүнг тооцож, шаардлагатай арга хэмжээг орон нутгийн нөөц боломжинд тулгуурлан тухай бүр шийдвэрлэж байх.

19. Энэхүү тогтоолын биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллан өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, үр дүнгийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчилж, сар бүр Засгийн газарт танилцуулж байхыг Ажлын хэсэгт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

**Засгийн газрын 2008 оны 290 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт**

## 2008-2009 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛЖ, ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

**Дарга** - Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболд

**Орлогч дарга:** - Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг;

-Түлш, эрчим хүчний сайд Ч.Хүрэлбаатар;

**Гишүүд:** - Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Төмөрхуяг;

-Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Гантулга;

-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Борбаатар;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мишигжав;

-Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ;

-Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Хүрэлбаатар;

-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Алтантуяа;

-Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Ц.Шийрэвдамба;

-Улаанбаатар хотын Ерөнхий менежер Ч.Бат.

**Нарийн бичгийн дарга** - Засгийн газрын ахлах референт Ж.Уранчимэг

**Засгийн газрын 2008 оны 290 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт**

## АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД 2008 ОНД БЭЛТГЭХ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН ДААЛГАВАР

| № | Сумын нэр | Бэлтгэх нийт тэжээл /мян.тн/ | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Бүдүүн | | | Хүчит | |
| | | Өвс | Сүрэл | Ногоон тэжээл | Үйлдвэрийн тэжээл | Гар тэжээл |
| | А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Архангай | 85.0 | 0.6 | 0.6 | | 1.0 |
| 2 | Баян-Өлгий | 45.0 | | | 10.0 | 2.6 |
| 3 | Баянхонгор | 25.0 | | | 1.0 | 3.5 |
| 4 | Булган | 80.0 | 4.0 | 3.0 | 9.0 | 1.5 |
| 5 | Говь-Алтай | 15.0 | 0.8 | 1.0 | 0.4 | 3.5 |
| 6 | Дорноговь | 8.5 | | | 0.2 | 2.0 |
| 7 | Дорнод | 55.5 | | 1.0 | 0.2 | 1.0 |
| 8 | Дундговь | 6.0 | | | 0.2 | 4.0 |
| 9 | Завхан | 30.0 | | 0.5 | 1.2 | 2.0 |
| 10 | Өвөрхангай | 35.0 | | | 2.0 | 2.0 |
| 11 | Өмнөговь | 3.0 | | | 0.5 | 5.0 |
| 12 | Сүхбаатар | 40.0 | | 0.2 | 2.0 | 3.0 |
| 13 | Сэлэнгэ | 120.0 | 15.0 | 4.5 | 10.0 | 0.8 |
| 14 | Төв | 80.0 | 6.0 | 2.5 | 8.0 | 1.0 |
| 15 | Увс | 35.0 | 1.0 | 0.5 | 1.5 | 3.5 |
| 16 | Ховд | 30.0 | | | | 3.7 |
| 17 | Хөвсгөл | 65.0 | 1.0 | 0.3 | 0.6 | 0.5 |
| 18 | Хэнтий | 60.0 | 3.2 | 0.6 | 0.5 | 1.5 |
| 19 | Дархан-Уул | 46.0 | 1.0 | 1.2 | 3.6 | 0.2 |
| 20 | Орхон | 8.0 | 1.5 | 0.6 | 0.4 | 0.1 |
| 21 | Говьсүмбэр | 4.5 | 0 | 0 | 0.3 | 1.2 |
| 22 | Улаанбаатар | 45.0 | 0 | 0.4 | 16.7 | 0.3 |
| | Улсын дүн | 931.5 | 34.1 | 16.9 | 68.3 | 43.9 |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.
Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Улаанбаатар- 12 Төрийн ордон
☎ 265958
Индекс 14003
☎ 329487
Хэвлэлийн хуудас 3.5